БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Д.БУДЖАВ

20..19..ОНЫ.....02..Р САРЫН.....06..-НЫ ӨДӨР.

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2019.01.17-НЫ ӨДРИЙН 01/475 ТООТ АЛБАН БИЧГЭЭР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Зөвлөмжийн дугаар, өгөгдсөн үүрэг даалгавар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага, эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж 1. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин гарч байгаад дүгнэлт хийх, таслан зогсоох. | 1.1. Эрх бүхий албан тушаалт(ЭБАТ)-нуудыг чадавхжуулах сургалтанд хамруулж, нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулсны дараа томилж, нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ээ хугацаандаа гаргаж хэвшүүлэх. | Тухай бүр | ИТХ-ын дарга<br>Засаг дарга<br>ЭБАТ |
| 2 | | 1.2.ТАЗ-ийн дүгнэлтгүй, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй, тэнцээгүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэдийг томилохгүй байх, зөрчлийг арилгах. | 3 сараас | Засаг дарга<br>ЗДТГ-ын дарга |
| 3 | Зөвлөмж 5. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг чангатгах, хугацаа хэтэрсэн зээлийг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, тус сангийн дансанд бусад эх үүсвэр бүхий хөрөнгийг байршуулахгүй байх, албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгосон гэмт хэргийг давтан гаргуулахгүй байх. | 5.1. СХС-ын зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавьж төлүүлэх арга хэмжээ авах | 3 дугаар сараас | Засаг дарга<br>ЖДҮ хариуцсан мэргэжилтэн |
| 4 | | 5.2.МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.4-д заасны дагуу тус сангийн хөрөнгөөс бусад хөрөнгийг уг дансанд байршуулахыг хориглох. | 3 дугаар сараас | Засаг дарга<br>ЖДҮ хариуцсан мэргэжилтэн |
| 5 | | 5.3. Албан тушаалын давуу байдлыг ашиглаж, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгохыг хориглох, хяналт тавих | 3 дугаар сараас | Засаг дарга<br>ЖДҮ хариуцсан<br>ЭБАТ |
| 6 | Зөвлөмж 6. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй Засаг даргаас хамтран ажиллах гэрээ байгуулан хандив | 6.1.Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй сумын Засаг даргаас хамтран ажиллах гэрээ байгуулан хандив цуглуулдаг, хандивын хөрөнгийг зориулалтын | 2 дугаар сараас | Засаг дарга<br>Байгаль орчны байцаагч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | цуглуулдаг, хандивын хөрөнгийг зориулалтын бусаар дур мэдэн хяналтгүйгээр зарцуулдаг явдлыг таслан зогсоох._ | бусаар зарцуулдаг явдлыг гаргахгүй байх, хяналт тавих | | |
| 7 | Зөвлөмж 11. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр хуульд заасны дагуу тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах, хавтаст хэрэгт үнэлгээний хорооны гишүүний худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээ /АЗ/-ыг заавал хавсаргаж хэвшүүлэх | Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр хуульд заасны дагуу тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, хавтаст хэрэгт үнэлгээний хорооны гишүүний худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээ /АЗ/-ыг заавал хавсаргаж хэвшүүлэх | Тухай бүр | Засаг даргын орлогч |
| 8 | Зөвлөмж 13. Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ыг хэрэгжүүлэх, журмын 4.1-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших. | 13.1.Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр /хуулбар/-ын хамт цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх. (Мэдээллийг харьяалах байгууллагын цахим хуудас буюу мэдээллийн самбарт Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацааг дуустал хугацаанд байршуулна) | Тухай бүр | Засаг дарга ЭБАТ Байгууллагын дарга нар |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ГАЗРЫН ЭБАТ З.СОЛОНГО